

АРХАНГАЙ АЙМГИЙН БЭЛЧЭЭРИЙН УРГАМАЛЖИЛТ ТҮҮНИЙ ЗАРИМ ОНЦЛОГ

Я.Баасандорж (Ph.D)*,
Д.Зооёо (Ph.D)**, С.Бадрах*
*Геоэкологийн хүрээлэн
**Ботаникийн хүрээлэн

Abstract

In this paper, we have discussed about the results of vegetation cover and census of plant species in Arkhangai province. The result shows that there are 601 species of fodder valuable plants from total 946 species, 231 types and 81 groups of plants in this province.

While Khangai, Undur-Ulaan and Erdenemandal soums of Tuv aimag have more potential for pasture but Jargalant, Tuvshruuleh and Ugiinuur soums have very limited potential for pasture.

Түлхүүр үг: Ургамалжил, ургамлын овог, төрөл, зүйл, ургамлын тусгаг бүрхэц, зүйлийн бүрэлдэхүүн, бэлчээрийн ургац

Оршил

Мал аж ахуйд хамгийн хямд үнэтэй экологийн цэвэр бүтээгдэхүүн нь байгалийн бэлчээр юм. Иймээс бэлчээрийн ургамалжилтыг бүс нутгийн хэмжээнд (аймаг, сумаар) судлах нь нэн чухал асуудлын нэг. Сүүлийн үеийн судалгаанаас үзэхэд бэлчээрийн талбайн 70 шахам хувь нь ямар нэг доройтол, талхлагдалд орж байна.

Цаашид бэлчээрийн ургамлын бүтэц, бүрэлдэхүүнийг судлаж, зохистой ашиглах, сэргээн сайжруулах, унаган төрхөөр нь хадгалах шаардлага бидний өмнө тулгарч байна.

Судлагдсан байдал, арга зүй

Манай орны бэлчээрийн ургамалжилтын судалгааг 1920-иод он хүртэл Оросын эрдэмтэдийн олон удаагийн экспедицийн судалгаанаас эхлэлтэй билээ. Эдгээр экспедици оролцогч эрдэмтдийн замын тэмдэглэл, тайлан, бүтээлүүдэд Монгол орны ойт хээр, хээрийн ургамалжилтын талаар чухал мэдээ сэлт байдаг.

1930-1960-аад онд Е.М.Лавренко, А.А.Юнатов, И.А.Цаценкин, В.И.Грубов зэрэг нэрт эрдэмтэд нэлээд сайн судалсан байна.

И.А.Губанов (1989, 1996), Э.Ганболд (1989), Д.Магсар (2003) нарын судалгааны ажил нь Хангайн нурууны бэлчээрийн ургамалжилт түүний тархалт, зүйлийн бүрэлдэхүүн, ховор ургамлыг нарийвчлан судалсан нь онцгой ач холбогдолтой болжээ.

2000-2005 онуудын ургамалжилтын судалгаа, Монгол орны ургамалжилтын 1:1000000 масштабын зураг, бэлчээрийн зураглал, тэжээлийн нөөцийг тооцсон олон эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдийн эрдэмтэд судалж, нэн их материалыг цуглуулсан байна.

Бид өндөр уул, ойт хээр, хээрийн бүс, бүслүүрийн бэлчээрийн ургамалжилт түүний онцлог, зүйлийн бүрэлдэхүүн, малд идэгдэх ургац, тэжээлийн нөөц, ургамлын аймгийн овог, төрөл, зүйлээр нь тооцож, судалгааны дүнд тусгав.

Ургамлын аймгийн овог, төрөл, зүйлийг илрүүлэх судалгааг явуулахдаа бүх сумдын нутгийг хамарсан маршрут судалгааг явуулан, ургамлын бичиглэл хийж, аймаг, сумын нэгдсэн ургамлын төрөл, зүйлийн жагсаалтыг гаргасан болно.

Судалгааны үр дүн

Байгалийн нөхцөл, хөрс газарзүйн онцлог. Архангай аймаг нь Манай орны төв хэсэгт орших ба ой тайга, уулын ба хээрийн ургамал хосолсон нийтдээ 5531.8 мян, га нутаг дэвсгэртэй.

Тус аймгийн нутаг нь баруун болон төв хэсгээрээ Хангай нурууны өндөрлөг уулын нугын хээр, зүүн талаараа ухаа гүвээт тал болон тэгш өндөрлөгт байрладаг.

Тус аймгийн нутаг нийтдээ уулархаг тул өвлийн улирал нилээд хүйтэн урт ба зун богино, сэрүүвтэр байдаг. Аймгийн нутаг агаарын температурын хэлбэлзэл ихтэй төдийгүй уулархаг нутагтаа жилийн дундаж температур -3.0 хэм байхад нам дор байрлалтай хээрийн бүсдээ +0.9 хэм байдаг байна.

Уулархаг хэсэгтээ хамгийн хүйтэн 1-р сард -23.2 хэм байхад хээр талдаа -16.3 хэм байна. Жилд дунджаар 360.0мм хур тунадас унадаг.

Бэлчээрийн ургамалжилт

1981 онд сансраас авсан бэлчээрийн 1:100000 масштабын ургамалжилтын зураг болон бидний судалгааны дүнгээс үзэхэд өндөр уулын бэлчээрийн ургамалжилт 142.3 мянган га буюу 4.0 хувь, ойт хээрийн ургамалжилт 2181.7 мянган га буюу 57.0 хувь, тал хээрийн ургамалжилт 950.7 мянган га буюу 25.0 хувь, голын хөндий ба нам хотсын ургамалжилт 528.2 мянган га буюу 14.0 хувь тус тус эзэлж байна.

Бүс, бүслүүрийн бэлчээрийн ургамалжилтийн онцлог болон ургамлын зүйлийн бүрэлдэхүүн, малд идэгдэх дундаж ургацын байдлыг илтгэлд товч дурьдсан болно.

Ургамалжилт, ургамлын аймгийн онцлог. Бид тус аймгийн ургамалжилтыг ботаник-газарзүйн бүсчлэл ба ургамлын аймгийн бүтэц, бүрэлдэхүүнийг тооцохын зэрэгцээ нэн ховор, ховор ургамлын тархалт байршилтыг тогтоолоо.

Бүх сумдын нутаг дэвсгэрээр явж, маршрут судалгаа хийснээс гадна Монгол-Оросын хамтарсан биологийн экспедицийн материалыг үндэслэн сумдын ургамлын жагсаалтыг гаргасны үндсэн дээр Архангай аймагт нийтдээ ургамлын **81** овог, **231** төрөл, **946** зүйл ургамал байгааг бүртгэж тооцов.

Тус аймагт бүртгэгдсэн овгоос үетэн, нийлмэл цэцэгтэн, уруул цэцэгтэн, улалж, тэргүүлэгч цэцэгтэн орж байна.

Томоохон төрлүүдээс: улалж, шарилж, гичгэнэ, бургас, хунчир, үетэн, банздоо зэрэг орно.

Аймгийн бүх сумдын ургамлыг овог, төрөл, зүйлээр ялгаварлан гаргаж дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 1

Ургамлын аймгийн овог, төрөл, зүйлийн жагсаалт

№	Сумдын нэр	Овог	Төрөл	Зүйл
1	Батцэнгэл	52	172	295
2	Булган	67	242	451
3	Жаргалант	58	174	337
4	Ихтамир	72	242	460
5	Өлзийт	43	118	219

6	Өгийнуур	40	117	198
7	Өндөр-Улаан	61	203	415
8	Тариат	66	215	425
9	Цахир	50	105	275
10	Хайрхан	46	158	156
11	Хангай	68	201	352
12	Хашаат	37	165	210
13	Хотонт	51	145	261
14	Цэнхэр	71	260	419
15	Цэцэрлэг	49	164	269
16	Чулуут	58	154	303
17	Эрдэнэмандал	55	146	246
18	Төвшрүүлэх	53	145	227

Дээрх хүснэгтээс үзэхэд Ихтамир, Булган, Тариат, Өндөр-Улаан, Цэнхэр, Хангай зэрэг сумдад 400 гаруй зүйл ургамал бүртгэгдсэн бол Хашаат, Өлзийт, Өгийнуур, Цэцэрлэг зэрэг сумдад 200 гаруй зүйл ургамал бүртгэсэн болно.

Тус аймагт ургаж байгаа байгалийн ургамлыг тэжээллэг ба эмчилгээний чанар ач холбогдолоор нь ангилж үзэхэд эмийн ба ашигт ургамал 283 зүйл, тэжээлийн ач холбогдолтой 601, нэн ховор 19, ховор 35 зүйл ургамал тархаж байгааг энэхүү судалгаагаар тогтоолоо.

Бэлчээрийн ургац ба тэжээлийн нөөц

Бид тус аймгийн ургамлын тоо бүртгэлийг явуулсанаас гадна бүх сумдын бэлчээрийн нэг га-ын ургацыг тодорхойлж, тэжээлийн нөөц, хүрэлцээг тооцож, дараах хүснэгтэнд үзүүлэв (Хүснэгт 2).

Хүснэгт 2

Архангай аймгийн бэлчээрийн даац

№	Сумын нэр	Нийт бэлчээрийн талбай, мян.га	Нэг га-ийн ургац, цн	Нийт тэжээлийн нөөц, мян.цн	Жилд байх хонин толгой, мян.тол
1	Батцэнгэл	315.1	3.8	1197.5	193.1
2	Булган	152.4	4.4	670.8	108.2
3	Жаргалант	89.7	2.9	260.2	42.0
4	Ихтамир	261.1	3.9	1018.3	164.2
5	Өлзийт	161.8	2.8	453.1	83.3
6	Өгийнуур	158.9	2.1	333.6	61.8
7	Өндөр-Улаан	326.5	4.2	1371.5	253.9
8	Тариат	152.1	4.9	745.3	138.1
9	Цахир	152.1	4.6	699.7	129.6
10	Хайрхан	194.8	4.2	818.4	141.1
11	Хангай	330.8	3.8	1257.1	202.8
12	Хашаат	251.1	2.8	703.0	130.9
13	Хотонт	179.3	3.6	645.6	111.3

14	Цэнхэр	139.6	4.5	628.1	108.3
15	Цэцэрлэг	196.0	4.2	800.5	138.0
16	Чулуут	254.7	4.3	1095.3	188.8
17	Эрдэнэмандал	305.7	4.8	1467.6	253.1
18	Төвшрүүлэх	82.9	4.1	339.8	58.5
	Дүн	3802.8	3.9	14505.4	2507.4

Бэлчээрийн нэг га-гийн ургацыг тооцсоны үндсэн дээр бүх сумдын тэжээлийн нөөц, жилд байх хонин толгойг тооцооны аргаар тодорхойлов. Энэхүү тооцооноос үзэхэд бэлчээрийн талбай хэмжээ, нэг га-гийн ургацаас хамаарч жилд байх хонь толгойн хэмжээ сум бүрд харилцан адилгүй байна. Тухайлбал Жаргалант, Төвшрүүлэх, Өгийнуур зэрэг сумдад байх хонин толгой 42.0-61.8 мян.тол байгаа бол Хангай, Өндөр-Улаан, Эрдэнэмандал зэрэг суманд 202.8-252.0 мян.тол байна.

Дүгнэлт

1. Тус аймгийн байгалийн ургамлын тооллого бүртгэлээр ургамлын аймагт 81 овог, 231 төрөл, 946 зүйл байгааг тогтоов. Энэ нь тус аймаг Хангай, хээр, говийн ургамалжилтын өвөрмөц хэв шинж төрхийг хадгалсан байгалийн ургамлын овог, төрлөөр нэлээд баялаг, нөөц арвинтайг харуулж байна.
2. Ургамлын аймгаас 19 нэн ховор, 25 ховор, 601 зүйл тэжээлийн ач холбогдолтой, 283 ашигтай зүйл ургамал байна.
Эдгээр ургамлын тархалт, биологийн онцлогийг харгалзан үзэж нөөцийг арвижуулах, нөхөн сэргээх шаардлагатай байна.
3. Аймгийн Жаргалант, Төвшрүүлэх, Өгийнуур зэрэг сумдын бэлчээр хүрэлцээгүй байгаа бөгөөд Хангай, Өндөр-Улаан, Эрдэнэмандал сумдын бэлчээр хүрэлцээтэй байна.

Ашигласан ном, хэвлэл

1. “Архангай аймгийн бэлчээрийн төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа” хийсэн ажлын тайлан, сүлжээний зураг. М.1:100000. УБ.2002
2. Аваадорж Д. Бадрах С. Баасандорж Я., 2006. *Бэлчээрийн хөрсний физик шинж чанар ба ургамлан нөмрөг, тэдгээрийн өөрчлөлт*. УБ. Х.167-177
3. Баасандорж Я. Бадрах С. Зооёо Д., 2004. “Архангай аймгийн байгалийн ургамлын тооллого, бүртгэл” ажлын тайлан. УБ. Х. 9-21
4. Губанов И.А. Ганболд Э., 1989. *Флора Хангая*. Л. Наука с.21-115
5. Губанов И.А., 1996. *Конспект флоры внешней Монголии (сосудистые растения)* М. Валант. с.11-108
6. Өлзийхутаг Н., 1985. *Монгол орны ургамлын аймаг, ургамалжилт*. УБ. Х.19-35
7. Юнатов А.А., 1950. *Основные черты растительного покрова МНР*. М-Л.